



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 23 (160)

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг:

- Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай
- Монгол Улсын Засгийн газрын тогтоол:
- Гаалийн албан татварын хувь, хэмжээг өөрчлох тухай
  - Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот  
2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны зургадугаар сарын 21 № 23 (160)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

249. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 88	457
---	-----------	-----

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

250. Гаалийн албан татварын хувь, хэмжээг өөрчлөх тухай	Дугаар 57	460
251. Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай	Дугаар 62	461
252. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх талаар авах нэмэлт арга хэмжээний тухай	Дугаар 67	463

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 5 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар  
хот

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, шинжлэх  
ухаан, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, шуух,  
прокурор, цагдаа, төр захирагаа болон төрийн бус  
байгууллагад олон жил амжилт гарган ажиллаж  
байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар  
шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТҮГИЙН ОДОНГООР:

1.Лувсангийн Агаанжамбал-Хэнтий аймгийн  
Хэрлэн сумын иргэн, ахмад уран бүтээлч  
2.Чогсомжавын Буриад -Монголын  
үйлдвэрлэлийн хоршооллын төв холбооны  
өрөнхийлөгч  
3.Дамдинсүрэнгийн Бямбаа -Улаанбаатар  
хотын нийтийн аж ахуйг сайжруулах төслийг удирдах  
нэгжийн захирал

4.Бизъяагийн Дашзвэг - Монголын  
радио телевизийн Боннд суугаа сурвалжлагч  
5.Жамъянгийн Доржпүрэв -Радио  
нэвтрүүлах төв станцын ахлах инженер  
6.Дашдоржийн Дэмбэрэлцэрэн -Монгол  
Улсын Дээд шүүхийн өрөнхий шүүгч асан  
7.Гомбын Загдрагчаа -Улаанбаатар

хотын Багшийн коллежийн математикийн багш  
8.Зундуйн Жанхаадорж - Байгаль  
орчны яамны ахлах мэргэжилтэн  
9.Хорлоогийн Мэнхбаяр - Улсын  
багшийн их сургуулийн биологийн тэнхмийн эрхлэгч  
10.Эрдэнэйн Нордов -Монгол улсын их  
сургуулийн Шинэ материалын хими, технологийн  
төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга

11.Рэнжавын Норовоо -Нийслэлийн Баян  
зүрх дүүргийн 8 дугаар цэцэрлэгийн арга зүйч багш  
12.Нямдолгорын Самилноров - Монгол  
Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах  
улсын комиссын нарийн бичгийн дарга

13.Ерөөлтийн Цоомоо - Монголын  
үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоодын холбооны  
тэргүүн

14.Очиржавын Цэрэнпүрэв -Нийслэлийн  
"Автобус - 3" компанийн автобусны жолооч  
15.Дашдоржийн Цэрэнтогтох -Үйлдвэр,  
худалдааны "Ээрмэл" ХК-ийн тамирын арга  
зүйч, худалдаа арилжааны мэргэжилтэн  
16.Очиржав Шагдаржав -Говьсүмбэр аймгийн  
Шивээговь сумын "Шивээ-Овоо" ХК-ийн гүйцэтгэх  
захирал



## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Шаравын Нина -Зэвсэгт хүчний 109 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа

### “АЛТАН ГАДАС” ОДОНГООР:

1. Цэвэгжавын Авид -Хөвсгөл аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын ерөнхий эмч

2. Самбуугийн Баатарсүх -Чөлөөт уран бүтээлч, хөгжмийн зохиолч

3. Рэнцэнгийн Бадарч -Увс аймгийн Тэс сум дахь сум дундын нэгдсэн эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүдийн их эмч

4. Жамъянгийн Балжинням -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны Засаг дарга

5. Тамирын Батбаяр -“МИАТ” компанийн нислэгийн аюулгүй байдал хариуцсан захирап

6. Даваажавын Батсайхан -Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгч

7. Шагдарсүрэнгийн Батсүх -Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн улсын байцаач

8. Сэрээтэрийн Battomer -Улсын ерөнхий прокурорын туслах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга

9. Нацагдоржийн Батцэцэг -“Эм-Би-Ай” ХХК-ийн “Монголжин” бичил театрын захирап

10. Гомбын Баянжаргал -Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн

11. Сэр-Одын Баярмагнай -Радио нэвтрүүлэх төв станцын зэлжийн ахлагч

12. Дамбачоймболын Болд -Дорноговь аймгийн Айраг сумын Засаг дарга

13. Жижгийн Болдбаатар -Монгол улсын их сургуулийн түүхийн тэнхмийн эрхлэгч

14. Санжаажамцын Бор-Өвгөн -“МИАТ” компанийн бэлтгэн хангах албаны ерөнхий менежер

15. Цэрэнбалжирын Бүжинлхам -Монгол улсын Дээд шүүхийн Тамгын хэлтсийн дарга

16. Жагваралын Бүрэнбэх -Сонгодог урлагийн академик театрны уран сайхны удирдагч

17. Түвшнэгийн Гунаажав -Монгол улсын

их сургуулийн биологийн факультетийн биофизикийн тэнхмийн эрхлэгч

18. Ломбоцэрэнгийн Гүржав -Техникийн их сургуулийн Компьютерийн техник, менежментийн сургуулийн зөвлөх багш

19. Гомбожавын Дааш -“МИАТ” компанийн АН-24, АН-26 онгоцны нисгэх багийн дарга, нисгэгч

20. Сэнгийн Дашдондов -Монголын өмгөөлөгчдийн холбооны өмгөөлөгч

21. Лүндэгийн Дашдондог -Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

22. Дашиямын Дашжамц -Дорнод аймгийн Баян-Уул сумын Засаг даргын Тамгын газрын мал зүйч

23. Бадамын Дашиям -Орхон аймгийн прокурор

24. Дашдондогийн Долгор -Нийслэлийн 16 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

25. Рэнцэнгийн Доржотов -“МИАТ” компанийн нислэгийн албаны орлогч дарга, багш-нисгэгч

26. Нямжавын Дугарсүрэн -“Хаадын сан”-гийн гүйцэтгэх захирап

27. Цэндийн Дуламжав -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Ахмадын хорооны зохион байгуулагч

28. Суриын Дэжид -Дундговь аймгийн Сайнцагаан сумын “Бөхт” ХХК-ийн захирап

29. Цэвэгдоржийн Дэлгэрсайхан -“МИАТ” компанийн БОИНГ-727 онгоцны нисэх багийн дарга, нисгэгч

30. Түндэвийн Зэвгээ -Анагаах ухааны их сургуулийн Эмгэг физиологийн тэнхмийн эрхлэгч

31. Рэгзэнгийн Жамъянчойжил -Монгол Улсын Дээд шүүхийн иргэний хэргийн танхимын тэргүүн шүүгч

32. Сэрээнэндоржийн Лхагвадорж -Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Засаг дарга

33. Данзангийн Лхамсүрэн -Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны Засаг дарга

34. Баасангийн Мягмар -Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

35. Аюушийн Найдан -Нийслэлийн “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХК-ийн



жолооч

36. Тогмидын Наранцэцэг - Нийслэлийн Хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн цэцэрлэгийн багш

37. Доржийн Нямаа - Шинжлэх ухааны академийн Физик, технологийн хүрээлэнгийн захирал

38. Намсрайн Ням-Осор - "Их засаг" хууль зүйн дээд сургуулийн захирал

39. Жанцанхорлоогийн Орилбий - Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Засаг дарга

40. Хасын Очир - Завхан аймгийн Сонгино сумын Засаг дарга

41. Дуламсүрэнгийн Оюунхорол - Гадаад хэлний "Отгонтэнгэр" их сургуулийн захирал

42. Даржаагийн Рина - Нийслэлийн 53 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

43. Жамбын Рэгзэн - Хувийн хэвшлийн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

44. Жамбалын Содномпэл - Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн дундговь аймгийн зөвлөлийн уяач

45. Боронхойн Содномцэрэн - Өмнөговь аймгийн шүүхийн шүүгч

46. Намжилбарамын Сүрэнхорлоо - Тээврийн прокурор

47. Бадрахын Төмөрбаатар - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Ноёнхангай" ХХК-ийн ерөнхий захирал

48. Төмөртогоогийн Төр - Орхон аймаг дахь Монгол Хятадын хамтарсан "Эржин" ХХК-ийн захирал

49. Гөлгөөгийн Улаантөмөр - Үйлдвэр, худалдааны "Эрэмэл" ХК-ийн засварчин

50. Чулуунбаатарын Үржинбадам - Монголын чөлөөт уран бүтээлчдийн холбооны гүйцэтгэх захирал

51. Ичинхорлоогийн Пүрэвдорж - Анагаах ухааны их сургуулийн биологи, удам зүй, дархлал судалын тэнхмийн эрхлэгч

52. Пулжингийн Цолモン - Овхөрхангай аймгийн Баянгол сумын Засаг дарга

53. Дамдинсүрэнгийн Цэвээндорж - Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн "Монголын археолог" төслийн удирдагч

54. Хандын Цэдэв - "МИАТ" компанийн коммерийн асуудал хариуцсан дэд захирал

55. Дугарын Цэндцэсэн - Нийслэлийн Багануур дүүргийн ахлах прокурор

56. Даашдоржийн Цэрэнбалжир - Нийс-

лэлийн Сүхбаатар дүүргийн ахлах прокурор

57. Бат-Очирын Цэрэнбалтав - Улсын ерөнхий прокурорын орлогч прокурор

58. Лувсандоржийн Цэрэнлхам - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн сувилагч

59. Банзрагчийн Цэрэннадмид - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Говь" ХК-ийн хэмжил зүй, электроникийн инженер

60. Намширын Чамбаа - "МИАТ" компанийн АН-24, АН-26 онгоцны нисгэх багийн борт механик

61. Санжаагийн Чулуунбаатар - Радио нэвтрүүлэх төв станцын зэлжийн ахлагч

62. Лувсанжамцын Чулуунбат - Ховд аймгийн Булган сумын Засаг дарга

63. Зогсохын Шаравсамбуу - Радио нэвтрүүлэх төв станцын засварын ахлах техникин

64. Цэрэндуламын Шийрэвдамба - Засгийн газрын тохируулагч агентлаг-Байгаль орчныг хамгаалах албаны дарга

65. Ёндонжавын Эрдэнэцэцэг - Нийслэлийн 5 дугаар дунд сургуулийн Монгол хэлний багш

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

Дорлигжавын Батхүү - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн дэд дарга, цагдаагийн дэд хурандаа

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Өлзий-Утасын Алтансэлэнгэ - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагч

2. Мангалын Амарсайхан - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хяналт, шалгалтын албаны дарга

3. Гомбын Бадарч - "МИАТ" компанийн шатахуун, тусгай үйлчилгээний авто баазын засварчин

4. Зэдээхүүгийн Батсуурь - Нийслэлийн "Эрчим хүчний барилгын угсралтын трест" ХК-ийн албаны дарга

5. Сүрэнгийн Батсуурь - Үйлдвэр, худалдааны "Эрэмэл" ХК-ийн ажилчин

6. Бүд-Очирын Бямбадорж - "МИАТ" компанийн Агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын АН-24, АН-26 онгоцны техникин



7. Бандийн Ганбаатар-Байгаль орчны яамны хамтын ажиллагааны хэлтсийн дарга

8. Нацагийн Гэрэлхүү -Ховд аймгийн Жаргалант сумын З дугаар дунд сургуулийн бага ангийн багш

9. Батаагийн Зүмүүхорол -"МИАТ" компанийн АН-24 онгоцны нисгэх багийн үйлчлэгч

10. Махбалын Намжилсүрэн -Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч

11. Харцагын Нансалмаа -Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Говь" ХК-ийн "Говь-2" үйлдвэрийн чанар шалгагч

12. Далхажавын Олзбаатар -Радио нэвтрүүлэх төв станцын эзлэжийн техникин

13. Сүрэнхорлоогийн Нарантуяа - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Говь" ХК-ийн зэрэгч

14. Пүрэвийн Нямаа -Орхон аймгийн санхүүгийн хяналт шалгалтын хэлтсийн улсын ахлах байцаагч

15. Жамсрангийн Пэлжээ -Дундговь аймгийн прокурорын газрын хяналтын прокурор

16. Мунын Төмөрбаатар -"МИАТ" компанийн шатахуун, тусгай үйлчилгээний авто баазын жолооч

17. Чулуунпүрэвийн Төрболд -Нийслэлийн 29 дүгээр тусгай сургуулийн шугам зургийн багш

18. Санжмятавын Цэвэл -Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын

цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга

19. Лувсандоржийн Цэдэнсодном

-Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын төвийн волейболын дасгалжуулагч

20. Батжаргалын Шагдарсүрэн -Баян-өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч

21. Цэвэгжавын Энхтуяа -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Эрүүл ахуй, халдварт судлалын хяналтын албаны эрүүл ахуйн улсын байцаагч

22. Жалцангийн Янжмаа -Ховд аймгийн нэгдсэн эмнэлгийн нүдний их эмч

## ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Юндэндоржийн Бадамханд - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтсийн хүүхдийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч

2. Дамдинсүрэнгийн Батжаргал -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтсийн цагдаа

3. Дащэрэнгийн Долгорсүрэн -Архангай аймгийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтсийн хүүхдийн ахлах байцаагч, цагдаагийн ахмад

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

**Гаалийн албан татварын хувь, хэмжээг өөрчлөх тухай**

Гаалийн тарифын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, "Засгийн газарт эрх олгох тухай" Улсын Их Хурлын 2000 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 28 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХНЬ:

1. Импортлох таваарын улаанбуудай, малын тэжээл, таримлын үр, бордоо, уграгал хамгааллын бодисын гаалийн албан татварын хувь, хэмжээг 2000 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс мөн оны 8 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд "О" байрхалыг өөрчилгэхийн

2. Хилийн Цагааннуур, Даян, Асгатын гол, Бургастай, Ариц суурь, Тэс, Давст, Тээл, Боршоо, Байтай, Ярант боомтоор импортлох гурлын гаалийн албан татварын хувь, хэмжээг энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хугацаанд "О" байхаар өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Сангиин сайд  
Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд

**Р.АМАРЖАРГАЛ  
Я.ОЧИРСҮХ**

**Ч.СОДНОМЦЭРЭН**



2000 оны 5 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

## Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай

Дорноговь аймгийн зарим сумдын нутагт олон улсын "A" жагсаалтын малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэг, тэдгээрт шилжих журам"-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Улаанбадрах, Эрдэнэ, Хөвсгөл, Сайншанд, Замын-үүд сумын нутгийг бүхэлд нь хорио цээрийн онцгой бүсэд, тус аймгийн бусад нутгийг хорио цээрийн хязгаарлалтын бүсэд хамруулан иргэний хамгаалалтын бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт, Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Дархан-уул, Орхон, Булган аймгийн нутгийн захирагааны болон хууль хамгаалах бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хамгаалалтын албадыг иргэний хамгаалалтын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт тус тус 2000 оны 4 дүгээр сарын 30-наас эхэн шилжүүлсүгэй.

2. Дорноговь аймгийн Засаг дарга Л.Ишдоржид даалгах нь:

а/иргэний хамгаалалтын штаб, мэргэжлийн ангиуд, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг зохих журам, удирдамжийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж А010 өвчний тархалтаас сэргийлэх, голомтыг устгах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсүгэй;

б/бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд иргэдийн зорчилт, бүх төрлийн тээврийн хэрэгсэл, малын шилжилт, хөдөлгөөний зогсоон журамлах арга хэмжээ авсугай.

3. Дорнод, Сүхбаатар, Дундговь, Өмнөговь, Говьсүмбэр, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Дархан-уул, Орхон, Булган аймгийн Засаг дарга нарт даалгах нь:

а/нутгийн захирагааны болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хамгаалалтын үйл ажиллагааг өндөржүүлсэн бэлэн байдлын удирдамжийн дагуу зохион байгуулсугай;

б/өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд иргэд, мал сүрэг, машин техникийн шилжилт, хөдөлгөөнийг хязгаарлах, журамлах арга хэмжээ авсугай;

в/мал эмнэлгийн нарийн мэргэжлийн хөдөлгөөнт отрядуудыг бэлэн байдалд оруулж, бүх сум, баг, хот айлын майд А010 өвчний шинж байгаа эсэхийг магадлан тогтооглох, малыг байнгын хариулаа маллагаанд оруулан хот айлуудын байршилыг харгалзан ойролцоогоо 15-20 хот айл тутамд малын эмч мэргэжилтэй хүн томилон хяналт тавиулж, малгчад мэргэжлийн зөвлөгөө, зааварчилга ёгүүлэх ажлыг зохион байгуулсугай.

4. Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжсэн аймгийн Засаг дарга нарт даалгах нь:

а/малын гоц халдварт А010 өвчний халдварт, тархалтаас сэргийлэх, голомтыг устгах, түүнчлэн иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжсэн тухай мэдээллийг нийтэд хүргэн ойлгуулах, таниулах арга хэмжээ авсугай;

б/А010 өвчний шинж тэмдэг, тархалт, халдварт хамгаалал, авч байгаа арга хэмжээний талаархи цагийн байдлыг зохих журмын дагуу Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, Улсын иргэний хамгаалалтын газарт мэдээлж байсугай.

в/энэ тогтоолын 3 дугаар зүйлийн "в"-д заасны дагуу хэсэгчлэн хяналтад оруулсан хот айлын майд өвчний сэжиг илэрсэн тохиолдолд түүнийг хорио цээрийн арга хэмжээнд яаралтай



оруулж, энэ талаар мэдээлэх, халдвартархааас хамгаалсан иж бүрэн арга хэмжээ авч байсугай.

**5.Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн даалгах нь:**

а/малын гоц халдварт өвчний тархалтын хүрээг бүрэн тогтоож, хорио цээр, хязгаарлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх бус нутгудын заагийг 2000 оны 5 дугаар сарын 5-ны дотор багтаан тодорхойлох арга хэмжээ авсугай;

б/гоц халдварт өвчний халдварын эх булаг, дамжсан зам, түүний үүсгэгчийн төрөл, хэвшил, онцлогийг шинжлэн тогтоож, тэмцэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулан хэрэгжүүлсүгэй;

в/хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүсүүдэд орох, гарах гол зам, гүүрүүдэд ариутгал, халдвартгүйжүүлэлтийн цэг байгуулж байнгын ажиллагаанд оруулсугай;

г/өвчний халдварын голомтыг устгах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсүгэй;

д/Засгийн газар, Улсын байнгын онцгой комиссын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг газар дээр нь хариуцан зохион байгуулах мэргэжлийн алба, мэргэжилтнүүдийн бэлэн байдлыг шуурхай ханггуулж, халдварын бус нутагт оруулж ажиллуулах арга хэмжээ авсугай;

е/иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэг шилжүүлсэн бус нутгудад А010 өвчинеэс урьдчилан сэргийлэх, уг өвчинтэй тэмцэх мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн арга хэмжээний талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах, гарын авлага, мэргэжлийн арга зүйн удирдлага, заавар зөвлөмжээр бүрэн хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтэд шуурхай мэдээлэх арга хэмжээ авч байсугай;

ж/гоц халдварт өвчний голомт, хорио цээр, хязгаарлалтын бусэд мөрдөн ажиллавал зохих дүрэм, журам, ариун цэврийн дэглэм, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж байсугай.

6.Малын гоц халдварт А010 өвчний үүсгэгчийн гарал, үүсэл, ийлдсийн хэвшлийг тогтоох, оношилгооны цомог олж нийлүүлэх, эмгэгт материалын дээж явуулж шинжлүүлэх асуудлаар холбогдох орон, олон улсын байгууллагад хандахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Гадаад харилцааны сайд Н.Туяа нарт үүрэг болгосугай.

7.Хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын бус тогтоосон нутаг дэвсгэрийг цэрэгжүүлсэн харуул хамгаалалттай болгохыг Батлан хамгаалахын сайд Ш.Түвшэндоржид даалгасугай.

8.Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх улс хоорондын ачааны болон олон улсын суудлын галт тэрэгний хөдөлгөөнийг хорио цээр, ариун цэврийн дэглэмийг сахиулан технологийн горимын дагуу зохицуулах арга хэмжээ авч ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газрын дарга Р.Раш нарт даалгасугай.

9.Улс хоорондын ачааны болон олон улсын суудлын галт тэрэгнээс бусад Дорнговь аймгийн нутгаар дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2000 оны 4 дүгээр сарын 30-наас эхлэн зогсоохыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүүд үүрэг болгосугай.

10.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлийн дагуу иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн аймгуудад хорио цээр, хязгаарлалт, халдварт хамгаалалтын арга хэмжээг иргэний хамгаалалтын төлөвлөгөө, тэдгээрийн тодотголын дагуу шуурхай зохион байгуулахыг Батлан хамгаалахын сайд Ш.Түвшэндорж, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга Д.Рэнцэнханд нарт даалгасугай.

11.Малын гоц халдварт А010 өвчний тархалтаас сэргийлэх, голомтыг устгах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эхний ээлжинд 148,6 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Сангийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

12.Хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбогдон гарах нэмэлт зардлын тооцоо,



үндэслэлийг тухай бүр гарган зохих журмын дагуу шийдвэрлүүлж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Батлан хамгаалахын сайд Ш.Түвшэндорж нарт даалгасугай.

**13.A010 өвчний тухай мэдээг нэгтгэн Засгийн газарт өдөр тутам танилцуулж байхыг Батлан хамгаалахын сайд Ш.Түвшэндорж, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт даалгасугай.**

**14.Хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүс нутагт мэргэжлийн баг томилон ажиллуулж, хүний эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээг сайжруулах, малаас өвчний халдварт авахаас урьдчилан сэргийлэх, эм, бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлэх, хүн амыг мэргэжлийн зөвлөмж, мэдээллээр хангах арга хэмжээ авахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонинд үүрэг болгосугай.**

**15.Цагдаагийн ерөнхий газрын дарга Ч.Амарболовдод даалгах нь:**

а/хорио цээрийн онцгой болон хязгаарлалт тогтоосон бүс нутгаас автомашин, мотоцикл, явган болон ердийн хөгслийн зорчих бүх төрлийн хөдөлгөөнийг зогсоох арга хэмжээг 2000 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 00 цагаас эхлэн хэрэгжүүлсүгэй;

б/хорио цээр, хязгаарлалт тогтоосон бүс нутагт нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсугай.

**Монгол Улсын Ерөнхий  
сайд**

**P.АМАРЖАРГАЛ**

**Хөдөө аж ахуй, үйлдвэрийн  
сайд**

**Ч.СОДНОМЦЭРЭН**

**Сангийн сайд**

**Я.ОЧИРСҮХ**

**Батлан хамгаалахын  
сайд**

**Ш.ТҮВДЭНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 5 дугаар  
сарын 5-ны өдөр**

**Дугаар 67**

**Улаанбаатар  
хот**

**Малын гоц халдварт өвчинтэй  
тэмцэх талаар авах нэмэлт арга  
хэмжээний тухай**

Монгол Улсын Засгийн газраас  
ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн зарим сумын нутагт гарсан малын гоц халдварт А010 өвчинтэй тэмцэх ажлыг удирдан зохион байгуулах Улсын байнгын онцгой комиссын штабын даргаар Байгаль орчны сайд, Улсын байнгын онцгой комиссын орлогч дарга С.Мэндсайханыг томилсугай.

2.Штабын дарга С.Мэндсайхан, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Дорноговь аймгийн Засаг дарга Л.Ишдорж нарт даалгах нь:

а/гоц халдварт өвчний голомтод байгаа адуунаас бусад малыг устахаж ажлыг 7 хоногийн дотор багтаан зохион байгуулах, устгасан малын хүүрийг мэргэжлийн

байгууллагын хяналтын дор хорио цээрийн дүрэм зааврын дагуу булшлах, халдвартгүйжүүлэх арга хэмжээ авсугай;

б/голомтоос гадна байгаа мал сүргийг вакцинуулах ажлыг Иргэний хамгаалалтын дайчилгааны журмаар 10 хоногийн дотор дуусгах арга хэмжээ авсугай;

в/малыг нь устгасан айл өрх, тэдний ам бүл, мөн устгагдсан малын судалгааг газар дээр нь нарийвчлан гаргаж албажуулах арга хэмжээ авсугай;

г/гоц халдварт өвчний голомтод орж мал нь устгагдсан айл өрхөд хорио цээрийг цуцалсаас хойш 7 хоногийн дотор багтаан малыг нөхөн олгох арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.



3. Малын гоц халдварт А010 өвчний архалтаас урьдчилан сэргийлэх, голомтыг стгах арга хэмжээнд зориулан зарцуулах 37700,0 (нэг зуун гучин долоон сая долоон зуун) янган төгрөгийг хавсралтад засны дагуу асгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг өнгийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсгүй.

4. Дорноговь аймгийн Улаанбадрах, өвсгөл сумын малын гоц халдварт А010 өвчиний эломнод өртөж малаа устгуулсан өрхийн хүн мын хүнсний хэрэгцээнд зориулан хорио зээрийн хугацаанд шаардагдах хүнсний зүйлийг 1рүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас атласан нормативын дагуу улсын нөөцөөс аргаж зарлагадахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн айд Ч.Содномцэрэнд, уг хүнсний үтээгдэхүүнийг нэр бүхий сумдын малаа стгуулсан айл өрхөд Улсын байнгын онцгой омиссын зардлаар хүргүүлэх арга хэмжээ вахыг Батлан хамгаалахын сайд Ш.Түвшэндорж нарт тус тус даалгасугай.

5. Дорноговь аймгийн нутагт зээр болон юусад зэрлэг амьтанд малын гоц халдварт А010 өвчний халдварт байгаа эсэхийг тодруулах судалгаа, шинжилгээ хийх мэргэжлийн хэсгийг омилон ажиллуулахыг Хөдөө аж ахуй,

үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Байгаль орчны сайд С.Мэндсайхан, Батлан хамгаалахын сайд Ш.Түвшэндорж нарт даалгасугай.

6. БНХАУ-ын Эрээн хотод хорио цээрийн улмаас хүлээлгэж байгаа манай улсын бүх төрлийн автомашин, тэдгээрийн зорчигчдиг нэг удаагийн арга хэмжээ болгон улсын хил нэвтрүүлж Замын-үүдэд ирүүлэх, эдгээр автомашин, зорчигчид болон Замын-үүдэд саатууллагаад байгаа автомашинтай иргэдийг ариун цэвэр, хорио цээрийн зохих дүрэм, журмын дагуу халдвартайжуулэх арга хэмжээ авч нарийн зохион байгуулалттайгаар иргэний хамгаалалтын бүх нийтийн бэлэн байдлын зэрэг шилжүүлсэн бүсээс гаргах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчны сайд, штабын дарга С.Мэндсайхан, Дорноговь аймгийн Засаг дарга Л.Ишдорж нарт үүрэг болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий  
сайд**

**P.АМАРЖАРГАЛ**

**Байгаль орчны сайд**

**C.МЭНДСАЙХАН**

**Хөдөө аж ахуй, үйлдвэрийн  
сайд**

**Ч.СОДНОМЦЭРЭН**

**Засгийн газрын 2000 оны  
67 дугаар тогтоолын  
хавсралт**

## ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ГАРГАХ НЭМЭЛТ ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Шаардагдах санхүүжилт (мян.төг)
1.	Мал устгах үйл ажиллагааны зардал	37200,0
2.	Вакцинжуулалтын зардал	92000,0
3.	Багаж хэрэгсэл	3000,0
4.	Зэрлэг ан амьтанд өвчний халдвартын судалгаа шинжилгээ хийх: а/ношлуур б/нисдэг тэрэг (нислэг) Бүгд	500,0 5000,0 5500,0
	Нийт дүн	137700,0

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12  
Т. 4-5. 6, 6, 6:

329612  
К.н.д.к. 4003

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

329487